



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠑ оны ᠒᠐ сарын ᠒᠑ өдөр

Дугаар А/᠒᠖᠖.

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн “Одонт манал” БГБХН өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн нийт 23,905,400.00 (хорин гурван сая есөн зуун таван мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Одонт манал” БГБХН өрхийн эрүүл мэндийн төв (Л.Оюунчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 16 нэр төрлийн татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 23,905,400.00 (хорин гурван сая есөн зуун таван мянга дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн “Одонт манал” БГБХН өрхийн эрүүл мэндийн төв (Л.Оюунчимэг)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10... дүгээр сарын 19... ны өдрийн 1466 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр : Сонгинохайрхан дүүргийн "Одонт манал" БГБХН өрхийн эрүүл мэндийн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан гижиг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжлтийн санал	ҮХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Микроскоф	10	ш	1	2,761,000.00	2,761,000.00	2,761,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
2	Био аюулгүй хайрцаг	10	ш	1	7,318,000.00	7,318,000.00	7,318,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
3	Лабораторын хөргөгч	10	ш	1	1,264,000.00	1,264,000.00	1,264,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
4	Компьютер	10	ш	4	1,489,800.00	5,959,200.00	5,959,200.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
5	Сүлжээний свич	10	ш	1	69,500.00	69,500.00	69,500.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
6	Иргэний үнэмлэх уншигч	10	ш	1	234,100.00	234,100.00	234,100.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
7	Хурууны хээ уншигч	10	ш	1	118,900.00	118,900.00	118,900.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
8	Тог баригч	10	ш	4	132,700.00	530,800.00	530,800.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
9	Компьютерын дэлгэц	10	ш	1	399,900.00	399,900.00	399,900.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
Тоног төхөөрөмжийн дүн													
					15	18,655,400.00	18,655,400.00						
2.Тавилга эд хогшил													
10	Коридорын хар сандал	10	ш	7	90,000.00	630,000.00	630,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
11	Коридорын саарал сандал	10	ш	9	120,000.00	1,080,000.00	1,080,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
12	Бор тумбочка	10	ш	8	80,000.00	640,000.00	640,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
13	Жижиг бор шүүгээ	10	ш	4	220,000.00	880,000.00	880,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
14	Шар шкаф	10	ш	1	180,000.00	180,000.00	180,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах
15	Дугуйтай хар сандал	10	ш	10	150,000.00	1,500,000.00	1,500,000.00	-	эвдэрсэн	актлах	актлах	татах	татах

